



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2020 оны 03 сарын 31 өдөр

Дугаар

А/213

Улаанбаатар хот

Төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн  
үнэмлэх хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дах хэсэг, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2020 оны 01 дүгээр сарын 24-ний 02-09-087/59 дүгээр дүгнэлт, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн захирлын 2020 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн “Диплом, дүнгийн хавсралтыг хүчингүйд тооцох тухай” А/37 дугаар тушаал, 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 2/321 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/543 дугаар тушаалаар Батбаатарын Билгүүнд олгосон S(r)091203/2018/02 дугаартай “Гэмтэл согог судлал” үндсэн мэргэшлийн үнэмлэхийг хүчингүй болгосугай.

2. Б.Билгүүний үндсэн мэргэшлийн үнэмлэхийг хүчингүй болгосонтой холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай:

2.1 Б.Билгүүний “Гэмтэл согог судлал” үндсэн мэргэшлийн сургалтын элсэлт, төгсөлтийн шалгалтын дүнг хүчингүй болгох;

2.2 Үндсэн мэргэшлийн үнэмлэх хүчингүй болгосон тухай мэдээллийг эрүүл мэндийн ажилтны нэгдсэн санд бүртгэж, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим хуудсанд байршуулан нийтэд мэдээлэх;

2.3 Үндсэн мэргэшлийн үнэмлэх хүчингүй болгосон талаар тус яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороо /Д.Цэрэндагва/, Гэмтэл согог судлалын мэргэжлийн салбар зөвлөл /С.Отгонгэрэл/, Гэмтэл согог судлалын үндэсний төв /Э.Галбадрах/, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль /Ж.Цолмон/, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Эрүүл мэнд, боловсрол, соёлын хяналтын газар /С.Сүнчин/, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Эрүүл мэнд, боловсрол, соёлын хэлтэс /Д.Цэнд-Аюуш/-т албан бичгээр тус тус мэдэгдэх.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

141200898